



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/93

Хужирт сум

Хязгаарлалтын дэглэмд шилжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, 18 дугаар зүйлийн 18.1, 18.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шунхлай 5 дугаар баг, Шивээт 4 дүгээр багийн нутагт 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс хойш шүлхий өвчний шинж тэмдэг илрээгүй тул сумын Засаг даргын “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” А/31 дүгээр захирамжийг цуцалж 2022 оны 05 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дээрх багуудын нутаг дэвсгэрт 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа малтай өрхүүдийн малд тандалт шинжилгээ хийж, хашаа хороог халдваргүйжүүлэх, мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга Б.Ичинхоролцэвэлмаад даалгасугай.

3. Хязгаарлалтын дэглэмийн үеэр хяналтын пост гаргаж техник хэрэгсэл, хүн хүч дайчлан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, шаардагдах шатах тослох материал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгсэл, ариутгалын бодисоор хангаж ажиллахыг Санхүүгийн албаны дарга Д.Уранчимэг нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга Б.Дэмбэрэлд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

92220118F